

**Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагыг
зохион байгуулах, хянан зохицуулах Үндэсний
зөвлөлийн хуралдааны тэмдэглэл**

Үндэсний зөвлөлийн хуралдаан 2007 оны 3 дугаар сарын 13-ны өдрийн 10 цаг 35 минутад Ерөнхий сайдын өрөөнд болов. Хуралдаанд Үндэсний зөвлөлийн гишүүн М.Энхболд, Д.Батбаатар, Ё.Гэрэлчулуун, П.Бямбацэрэн, Л.Жавзмаа, П.Очирбат, Ц.Ганболд, Д.Батбаяр нар оролцов. П.Эрдэнэжаргал гадаад томилолттой тул менежер Н.Дорждарь, Г.Уранцоож мөн томилолтоор яваа тул тус төвийн ажилтан Л.Ариунчимэг, Х.Наранхүү томилолттой тул орлогч захирал Ё.Баярсайхан, төлөөлөгчдийн газрын захирал Д.Цогбаатар нар оролцов. Ч.Улаан эмнэлэгт, И.Эрдэнэбаатар хөдөө томилолттой, Л.Гантөмөр хөдөө яваа тул хуралдаанд оролцоогүй, Н.Баяртсайхан хуралд ирээгүй болно. Хуралдаанд ажлын хэсгийн нарийн бичгийн дарга Э.Сумъяа, Дэлхийн банкны суурин төлөөлөгчийн газрын зөвлөх С.Хасар нар оролцов.

М.Энхболд хуралдааныг нээж, хэлэлцэх асуудлыг танилцуулж, өөр санал байгаа эсэхийг гишүүдээс асууж, хэлэлцэх асуудлыг гишүүд дэмжиж нэмэлт санал гараагүй хуралдааныг эхлүүлэв.

1. Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагыг үр дүнтэй хэрэгжүүлэх зорилгоор оролцогч 3 тал Засгийн газар, компаниуд, төрийн бус байгууллагын эвслийн хооронд байгуулах хамтын ажиллагааны санамж бичгийн төсөл (Үндэсний зөвлөлийн нарийн бичгийн дарга Д.Батбаяр танилцуулав)

М.Энхболд-За асуулт байна уу?

П.Очирбат-Төрийн бус байгууллагын эвсэл гэж байна уу, бүртгэлтэй юу?

Д.Батбаяр-Санаачлагад оролцогч 3 дахь тал болсон төрийн бус байгууллагын эвсэл байгуулагдсан. Эвслийн төлөөлөл Үндэсний зөвлөл, ажлын хэсэгт орж ажиллаж байгаа. Ц.Ганболд арай дэлгэрэнгүй мэдээлэл өгнө.

Ц.Ганболд-Өнгөрсөн оны 10 дугаар сард анх төрийн бус 16 байгууллага нэгдэж төрийн бус байгууллагын эвсэл байгуулагдсан. Одоо 20 байгууллага нэгдээд байна. Эдгээр төрийн бус байгууллагын үйл ажиллагааг нэгтгэн зохицуулах зөвлөл байгуулагдан ажиллаж байна, зохицуулагч нь би. Манайд нэгдэж байгаа төрийн бус байгууллагууд бүгд Хууль зүй, дотоод хэргийн яаманд бүртгэлтэй, харин эвсэл бүртгэлгүй.

П.Очирбат-Эвсэлд Соёмбо хөдөлгөөн зэрэг байгаа юу?

Ц.Ганболд-Соёмбо хөдөлгөөн нэгдээгүй, Миний монголын газар шороо хөдөлгөөн эвсэлд нэгдсэн. Эвсэл бусад төрийн бус байгууллагад нээлттэй байгаа.

П.Очирбат-Төсөлд компани гэж бичжээ. 280-иад компани үйл ажиллагаа явуулдаг.

Э.Сумъяа-Бүх компанийг зохион байгуулахтайгаа холбоотой үндэсний зөвлөл

П.Очирбат-Уул уурхайн ассоциаци, Нүүрс ассоциаци бүх компанийг төлөөлөхгүй, зөвхөн өөрийн гишүүдээ төлөөлнө. Бусдыг хэн төлөөлөх вэ?

Д.Батбаяр-Бүх компанийг оруулахад хүндрэлтэй. Санамж бичигт гарын үсэг зуруулах замаар санаачлагыг дэмжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулахаар төлөвлөж байна.

П.Очирбат-Ил тод байдлаас зугтах сонирхол Засгийн газарт ч бий, компанид ч бий. Гадаадын компаниуд охин компанитай. Компаниуд 2 баланстай, төв компани, охин компанийн хооронд гүйлгэж, ашигтайгаар нь алдагдалтайг нь нөхөж баланс гаргадаг. Үүнийг анхаарах.

Д.Батбаяр-Эхнээс нь бүх компанийг санаачлагад хамруулж зохион байгуулж чадахгүй, компаниуд сайн дураараа санаачлагад орно. Төрийн бус байгууллагын эвсэл бүх компаниар санаачлагын тайлан гаргуулая гэж байгаа.

П.Очирбат-Санаачлагын тайланг компани гаргана. Төсөлд Засгийн газар аж ахуйн нэгжээс хүлээн авсан албан татвар, төлбөрө тайлагнана гэжээ, үүний хамт зарцуулалтын тайлан гаргахаар төсөлд тусгая. Засгийн газар орлогын менежментийг зөв зохистой удирдах гэж төсөлд нэмж оруулая. Ашиглалтын тусгай зөвшөөрөл гэсэн байна шүү. Хайгуулын компани ч олборлолт явуулдаг учир үүнийг орхихгүй байх нь чухал.

Ц.Ганболд-Тайлангийн маягыг гаргах асуудал, тайлан гаргах дээр Д.Батбаяртай санал нийлэхгүй зүйл байна. Санаачлагад Засгийн газар сайн дураар нэгдэнэ. Засгийн газар нэгдсэн бол компаниуд заавал орно. Энд энэ онд 50 саяас дээш татвар төлсөн компанийг тайлагнуулая гэжээ. Энэ нь ноднингийн судалгаагаар 30 гаруй компани тайлагнах нээ. Киргиз Улс эхлээд зөв эхэлсэн, гадны санхүүжилт зогсохоор аудит хийхээ байсан. Дэлхийн банк, хандивлагчдаас тусламж авч байгаа дээр 384 компани тайлан гаргаж, нийтэд мэдээлнэ гэснийг хэрэгжүүлэх, ингэхгүй бол цаашид хэрэгжүүлж чадахгүй. Тайлан гаргасан ч аудит хийхгүй бол үр дүнд хүрэхгүй. Компаниудын болон Засгийн газрын тайлан хоорондоо мөргөж байгаа эсэхэд аудит хийгдэнэ. Энэ асуудлаар 3 тал нэг ширээнд суусан.

Д.Батбаяр-300 гаруй компанид аудит хийх чадвар манайд бий юу Жавзмаа даргаа.

Л.Жавзмаа-Санамж бичгийн зарчмыг төлөөллөөр хэрэгжүүлнэ. Төлөөллийг Үйлдвэр, худалдааны яам татаж оруулна. Төрийн аудит хийнэ. Хувийн хэвшлийн аудит хийх боломж бий.

Д.Батбаатар-Асуудлыг дэмжиж байна. Нэг санал хэлэхэд төрийн бус байгууллагыг жадлан эсэргүүцэж байна гэж битгий ойлгоорой, санаачлагыг хэрэгжүүлэх ажил хэлбэр төдий болох вэ! Төрийн байгууллага, хувийн хэвшил тайлан гаргадаг. Улсын мэргэжлийн хяналтын газар уул уурхайн салбарт хяналт хийдэг. Хийсэн шалгалтын дүнгээ мэдээлээд байдаг, тодорхой хариу, нухацтай яригддаггүй, харин иргэний хөдөлгөөнийхөн уул уурхайд очихоор л шуугидаг, төрийн байгууллага иргэний хөдөлгөөнүүдэд хөтлөгддөг болоод байна. Дорноговь аймагт өнөөдөр төрийн бус байгууллагууд очиж байна. Бүх байгууллагууд оны эхэнд ажлаа төлөвлөсөн, аудит хийлгэхэд ихээхэн зардал гарна. Засгийн газар сайн дураар нэглэнэ. санаачлагал бүх компанийг оруулах

хяналт тавина гэж байна. Хяналт гэдгийг чухам яаж ойлгоод байна вэ?

Ё.Баярсайхан-Бидэнд хийж байгаа үйл ажиллагаа маань ашиг олохоос гадна нийгэмд тодорхой хөрөнгө зарцуулж, уул уурхайн үйлдвэр болгон нийгмийн хариуцлагын тайлан гаргаж байна. Эрдэнэт уулын баяжуулах үйлдвэрээс Орхон аймагт оруулж байгаа хөрөнгө их ээ. Байгаль орчин хамгаалах, аймгийн иргэдэд зориулсан хөрөнгө гээд ихээхэн хөрөнгө зарцуулж байгаа. Би ноднин олон улсын хөдөлмөрийн байгууллагын хуралд суухдаа санаачлагын асуудалтай, нийгэмд зориулсан хөрөнгөө тайлагнахтай танилцсан. Нийгмийн хариуцлага гэдэг ойлголтыг энд оруулах хэрэгтэй байна. Сангийн яам, Төрийн өмчийн хороонд өгдөг тайланд ордог баримтууд энд орсон байна. Олон төрлийн аудит хийгддэг. Түүгээр зөрүү байвал гарна. Компани мэдээ гаргах уу, уялдаа холбоо харагдахгүй байна.

Д.Цогбаатар-Аудит хийх мөнгийг компани гаргана гэнэ. Аудитын зардлаа компани даана гэдгийг анхаарах.

Н.Дорждарь-Төслийн 6.8 дахь заалтыг аудит гэж өөрчлөөд 6.9 дэх заалт болгож олон улсын баталгаажуулалт хийлгэхээр оруулах саналтай. Хичнээн компани санаачлагад оролцох вэ гээд байна, бүх компани орно, дэлхийн банк, хандивлагчид санхүүжүүлж байхад аль болох олон компани оруулмаар байна.

М.Энхболд- Аудитын зардлаа өөрсдөө гаргах тал дээр хэвшсэн ойлголт шүү дээ. Дараахь замаар шийдвэрлэе.

ШИЙДВЭРЛЭСЭН нь: 1. Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагыг үр дүнтэй хэрэгжүүлэх зорилгоор оролцогч 3 тал Засгийн газар, компаниуд, төрийн бус байгууллагын эвслийн хооронд байгуулах хамтын ажиллагааны санамж бичгийн төслийг зарчмын хувьд дэмжиж, хуралдаан дээр зөвлөлийн гишүүдээс гаргасан саналыг судалж төсөлд тусган хэрэгжүүлэхээр тогтов.

2. Санамж бичигт Үндэсний зөвлөл болон ажлын хэсгийн гишүүдээр гарын үсэг зуруулах, оролцогч 3 талын төлөөлөл, санаачилгыг дэмжигч аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийг татан оролцуулж гарын үсэг зуруулах арга хэмжээ авахыг Үндэсний зөвлөлийн нарийн бичгийн дарга Д.Батбаярт даалгав.

3. Санамж бичиг, түүний агуулгыг нийтэд мэдээлэх, үр дүнтэй хэрэгжүүлэх талаар сурталчлах, хэвлэл мэдээллээр ярих, компани, иргэний хөдөлгөөнд ойлголт өгөх арга хэмжээ авахыг Үндэсний зөвлөлийн гишүүд, Засгийн газрын хэвлэл мэдээллийн албанд даалгав.

II. Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагын бэлтгэл хангах, цаашид үргэлжлүүлэн хэрэгжүүлэх ажлын шинэчилсэн төлөвлөгөөний төсөл (Д.Батбаяр танилцуулав)

П.Очирбат-төслийн 37-д улсын болон орон нутгийн төсөвт тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниас хүлээн авсан албан татвар, төлбөрийг хэрхэн зарцуулсан тухай Засгийн газрын тайлан гаргаж нийтэд мэдээлэх гэж нэмэх, Төгсгөлийн үр дүн гэсэн хэсэгт орлогын гэсний дараа болон Засгийн газрын зарлагын мөчөлмөнийг сайжруулах буюу оруулах

Ц.Ганболд-40-ийн хариуцах эзэн дээр ажлын хэсэг гэж оруулах

Н.Дорждарь-Баталгаажуулагчийг 3 тал сонгохоор тодруулж тусгах

П.Бямбацэрэн-Үндэсний зөвлөл сонгох юм биш үү.

М.Энхболд-өөр санал байхгүй бол дараахь замаар шийдвэрлэе.

ШИЙДВЭРЛЭСЭН нь: 1. Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын бэлтгэл хангах, цаашид үргэлжлүүлэн хэрэгжүүлэх ажлын шинэчилсэн төлөвлөгөөг зарчмын хувьд дэмжиж, хуралдаан дээр зөвлөлийн гишүүдээс гаргасан саналыг судалж тусган Үндэсний зөвлөлийн 2007 оны 3 дугаар сарын 13-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэж батлав гээд шууд батлая.

2. Хөрөнгө санхүүгийн байдлаас шалтгаалж төлөвлөгөөний хэрэгжих хугацааг өөрчлөн хэрэгжүүлэх эрхийг Ажлын хэсэгт олгов.

3. Ажлын шинэчилсэн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж, хяналт тавьж ажиллахыг Үндэсний зөвлөлийн гишүүдэд үүрэг болгож, сурталчлан хэрэгжүүлэхийг Үндэсний зөвлөлийн нарийн бичгийн дарга Д.Батбаярт үүрэг болгов.

III. ОУИТБС-ийн Тайлангийн маягт №1, №2, №3, №4, түүнийг гаргах, мэдээлэх зааврын төсөл (Д.Батбаяр танилцуулав)

М.Энхболд-Энэ маягыг Ерөнхий сайд батлах нь зөв үү.

П.Бямбацэрэн-Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиар Сангийн яам хянаж сайд батлах ёстой.

М.Энхболд-Үүнийг Ерөнхий сайд батлах эрх зүйн үндэслэл ямар вэ? Хуулиар бол хэн батлах вэ? Үндэсний зөвлөл дэмжээд Сангийн сайд батлах уу.

Ё.Баярсайхан-Үндэсний зөвлөл батлахгүй. Бодлого хариуцдагын хувьд Үйлдвэр, худалдааны яам батлах нь зүйтэй.

Н.Дорждарь-3 талын оролцоотой Үндэсний зөвлөл батлах нь зүйтэй.

Ц.Ганболд-Д.Батбаатар буруу ярьж байна. Санаачлага эхнээсээ ийм байдлаар явбал хэрэгжихгүй. Сангийн яаманд Үндэсний зөвлөл ч, Ерөнхий сайд ч үүрэг өгөх ёстой. Олон улсын жишгээр маягтаа 3 тал оролцсон Үндэсний зөвлөл хэлэлцээд, батлаад хэрэгжүүлж байгаа. Хяналт гэхээр их эмзэглэж байна, мониторинг гэдэг утгаар ойлгож байгаа. Оролцогч 3 тал бүхий Үндэсний зөвлөл тайлангийн маягтаа батлахгүй юм бол бусад нь хэрэггүй болж байгаа юм.

Д.Батбаатар-Хэргийн учир эндээс батлахаар аж ахуйн нэгж хэрэгжүүлэхгүй, аж ахуйн нэгжийн удирдлага Сангийн яам, Үйлдвэр, худалдааны яам батлаагүй гэх вэ гэж болгоомжилж байна.

П.Бямбацэрэн-Үндэсний зөвлөл хэлэлцээд дэмжие, Сангийн сайд батлая. Сангийн яам тайлангийн нэг талыг гаргах ёстой ч маягтаа батлаг.

батална.

М.Энхболд-За тэгвэл Сангийн сайдаар батлуулая.

П.Очирбат-Сангийн яам аж ахуйн нэгжүүдээс тайлан авдаг, энэ одоогийнхоос өөр, 2 тайлан гаргах нээ. Хуулийн дагуу л батлах ёстой. Сангийн яамны саналыг тусгах ёстой. Тайлан гаргах аж ахуйн нэгжийг 50 саяас дээш албан татвар, төлбөр төлсөн гэжээ, Бүх компанийг оруулж тайлагнуулая, жижгийг орхиж болохгүй, аж ахуйн нэгжүүд 2 кг алт олборлосон ч олборлолт явуулж байгаа, 2 кг алт олборлодог 200 аж ахуйн нэгж байхад улс 400 кг алт олборлож байгаа, энэ бол үйлдвэрлэл шүү. Тэмдэглэлийн төслийн 4 дүгээр заалт хэрэг байна уу, төрийн бус байгууллага гэдэг чинь хүн шүү дээ, тэд өөрсдөө ингэж орвол авилгалд орооцолдоно, ийм эрх ч байхгүй.

Э.Сумъяа-Тайлан гаргах маягт бол санаачлагын хүрээнд аж ахуйн нэгж албан татвар, төлбөр хэлбэрээр юу улсад төлөв гэдгээ, Сангийн яам аж ахуйн нэгжээс албан татвар, төлбөрөөр юу авав гэдгээ л нийтэд мэдээлэх хэлбэр, энэ 2-т зөрүү байна уу гэдэгт аудит хийдэг зүйл. Түүнээс нягтлан бодох бүртгэлийн асуудал энд байхгүй, төсөлд Сангийн яамны санал аваагүй гээд байна, ажлын хэсгийн гишүүд боловсруулахад оролцсон, тухайлбал, Татварын ерөнхий газрын Л.Зориг, Сангийн яамны газрын дарга Б.Батжаргал, Нягтлан бодогчдын институтын ерөнхийлөгч Л.Дондог нар оролцсон. Б.Батжаргалын өгсөн саналыг уншив. Сангийн яамны саналыг маягт, зааварт тусгасан. Тайлангийн маягыг олон улсын туршлагаар боловсруулж Дэлхийн банкнаас санал авсан, Дэлхийн банкны зөвлөх нэмэгдсэн өртгийн албан татвар хэрэг байна уу, аудит хийхэд хүнд байдаг гэсэн санал өгсөн. Зүй нь маягт, заавраа санаачлагын Үндэсний зөвлөл батлах нь зүйтэй, гэхдээ би төрийн тангараг өргөсөн албан хаагч тул гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх үүрэгтэй, маягтаа заавал Үндэсний зөвлөл батал гэсэн шахалт үзүүлж болохгүй байна.

М.Энхболд-Маягт, заавраа Сангийн сайд батлах болсон.

Ц.Ганболд-Гишүүд техникийн шинжтэй зүйл яриад байна, заавраа уншаагүй байна. Хөдөөд Засаг дарга өөрөө хандив авдаг, Ханбогд сумын Засаг дарга жийп унаад давхиж байна. Үүнийг ил тод нийгэмд мэдээлдэг болгох, төсөвт болон орон нутагт авсан зүйлээ Сангийн яам нэгтгэн тайлагнах үүрэг хүлээж байгаа. Ийм үүрэгтэй Сангийн яам маягт, заавраа баталбал Үндэсний зөвлөл байх хэрэггүй.

Ё.Баярсайхан-Үүрэг, хариуцлагын ялгаа, заагийг сайн гаргаад өгвөл хэн ч баталсан яах вэ!

М.Энхболд-Маягт, зааврыг Сангийн яам хянаж батлаг. Тайланг нь Үндэсний зөвлөл хэлэлцэе.

Ц.Ганболд-хэзээ батлах вэ? яаралтай батлах хэрэгтэй байна.

ШИЙДВЭРЛЭСЭН нь: 1. ОУИТБС Тайлангийн маягт №1, 2, 3, 4, түүнийг гаргах, мэдээлэх зааврыг зарчмын хувьд дэмжиж, хуралдаан дээр зөвлөлийн гишүүдээс гаргасан саналыг судалж тусган Сангийн сайдад хүргүүлэн батлуулахаар тогтов.

бичгийн дарга Д.Батбаярт үүрэг болгов.

3. Тайланг бүх аж ахуйн нэгжээр гаргуулж, харин 50 саяас дээш албан татвар, төлбөр төлсөнд нь аудит хийлгэхээр тогтов.

П.Очирбат-Жижиг компанийг оруулах хэрэгтэй шүү гэв.

Ү. Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагыг хэрэгжүүлэхэд Улсын Их Хурал болон Засгийн газрын талаас оролцох төрийн захиргааны байгууллагууд, тэдгээрийн чиг үүрэг (Д.Батбаяр танилцуулав)

П.Очирбат-Компаниуд, Төрийн бус байгууллагуудын чиг үүрэг байхгүй юу, оролцогч 3 этгээд байгаа бол 3-уулангийн чиг үүргийг зааж зангидаж өгөх нь зүйтэй. Нэр томъёо олон янз байна, үнэн зөв мэдээлэх, зарцуулалтын тайлан гаргах, төслийг уншихад 8 газар тайлан авах, шалгах юм байна.

Э.Сумъяа-3 талын чиг үүрэг санамж бичигт товч байгаа, харин Засгийн газрын тайлан гаргахад Засгийн газрын олон байгууллагууд оролцож байна, манай тогтолцоо өөрөө ийм байдалд хүргээд байна, аж ахуйн нэгжээс албан татвар, төлбөр авдаг агентлаг, төсөвт байгууллагууд Сангийн яамтай гэрээ байгуулсан, авсан мөнгөнийхөө тодорхой хувийг өөрийн байгууллагыг санхүүжүүлэхэд зарцуулдаг байна. Иймд эдгээр байгууллагын чиг үүргийг тодорхойлох шаардлагатай гэж үзэж үүнийг боловсруулсан. Харин компаниуд, төрийн бус байгууллагууд өөр өөрийн үүргээ боловсруулж Үндэсний зөвлөлд хэлэлцүүлж болно.

Д.Батбаатар- УИХ-ын байнгын хороодын үүрэг хэрэгтэй юу. Олон тайлагнах гэдгийг цөөлж найруулан дотроо тайлагнах гэдгээ ганц газар оруулая.

М.Энхболд-Улсын Их Хурлын харьяа байгууллагууд энэ чиг үүргийг зөвшөөрч байна уу.

Л.Жавзмаа-зөвшөөрч байна.

П.Бямбацэрэн-зөвшөөрч байна.

Л.Ариунчимэг-14-д иргэдэд мэдээлэх гэж оруулах

М.Энхболд-Байнгын хороод, Үндэсний аудитын газар, Үндэсний статистикийн газраас бичгээр санал аваад Засгийн газрын хуралдаанд оруулж батлая. Засгийн газрын тогтоолоор энэ чиг үүргийг батлая.

П.Очирбат-Компани, төрийн бус байгууллагын үүргээ яах вэ?

М.Энхболд-Оруулая.

ШИЙДВЭРЛЭСЭН нь: 1. Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгыг хэрэгжүүлэхэд Улсын Их Хурал болон Засгийн газрын талаас оролцох төрийн захиргааны байгууллагууд, тэдгээрийн чиг үүргийг зарчмын хувьд дэмжиж, хуралдаан дээр зөвлөлийн гишүүдээс гаргасан саналыг судалж тусган Засгийн газрын хуралданаар хэлэлцэж тогтоолоор батлахаар тогтов.

үүрэг болгож, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн бус байгууллагын эвсэлд хариуцуулав.

3. Компаниуд, төрийн бус байгууллагын чиг үүргийг боловсруулж Үндэсний зөвлөлийн хуралдаанд танилцуулах нь зүйтэй гэж үзэв.

Ү. Ажлын албаны дүрмийн төсөл (Д.Батбаяр танилцуулав)

П.Очирбат-Ажлын алба, ажлын хэсэг гээд янз бүрээр бичээд байгааг ойлгохгүй байна. 3.5, 7.4-ыг унших

Э.Сумъяа-Үндэсний зөвлөлийн доор ажлын хэсэг ажиллаж байгаа. Ажлын алба бол Дэлхийн банк болон хандивлагчдын мөнгөөр байгуулагдаж санаачлагын талаарх сургалт, тайлан авах гээд өдөр тутмын ажлыг эрхэлнэ. 2 хүнтэй байгуулагдахаар яригдаж байгаа. С.Батболд дарга Дэлхийн банкны зөвлөхүүдтэй уулзаад Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэргэд байгуулах, төрийн ордны ойролцоо өрөө түрээслэх, ажилтнуудыг олон улсын жишгээр сонгон шалгаруулж авах зэргийг тохирсон. Харин төрийн бус байгууллагууд Хэрэг эрхлэх газрын дарга ажилтнуудыг томилох гэдгийг зөвшөөрөхгүй байгаа.

Ц.Ганболд-Ажлын алба бол хөндлөнгийн, хэний ч харьяанд бус байна. Иймд эдгээр ажилтанг Хэрэг эрхлэх газрын дарга томилж болохгүй, тэгвэл төрийн албаны ажилтан болох гээд байгаа юм.

М.Энхболд-Эдгээр ажилтанг Үндэсний зөвлөлийн дарга томилоё.

ШИЙДВЭРЛЭСЭН нь: 1. Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгыг хэрэгжүүлэх ажлын албаны дүрмийг зарчмын хувьд дэмжиж, хуралдаан дээр зөвлөлийн гишүүдээс гаргасан саналыг судалж тусган батлахаар тогтов. Ажлын албаны ажилтанг Үндэсний зөвлөлийн дарга томилох нь зүйтэй гэж үзэв.

2. Энэхүү дүрмийг хэрэгжүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Үндэсний зөвлөлийн нарийн бичгийн дарга Д.Батбаярт үүрэг болгов.

ҮІ. Үндэсний зөвлөлийн ажиллах журамд өөрчлөлт оруулах тухай (Д.Батбаяр танилцуулав)

П.Очирбат-Уул уурхайн ассоциаци бүх компанийг Үндэсний зөвлөлд төлөөлөхгүй, компанийн төлөөллөө нэмэх, гадны хөрөнгө оруулалтгүй 2 том компани нэмэх, Монголын алт корпораци Нямтайшир, Монгол газар Мянганбаяр гээд байж л байна.

М.Энхболд-Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны дарга байхад Төсвийн байнгын хорооны дарга байх хэрэгтэй юү?

Э.Сумъяа-Ажлын хэсэгт Уул уурхайн ассоциаци, Нүүрс ассоциациас гадна Монголын алт корпораци Б.Нямтайшир, Монгол газар Ц.Мянганбаяр, Бороогоулд н.Сандаг, Авенхоумайнзын А.Мөнхбат нар байгаа. Бүх асуудлыг хэлэлцүүлэхэд оролцож байгаа. Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүн бол билчээс

М.Энхболд-Уул уурхайн ассоциацийн хүндэт ерөнхийлөгч гэж байна, хэн билээ.

П.Очирбат-Би ухаантай юм аа.

М.Энхболд-Журмаас тэгш гэдэг үгийг хасах уу.

ШИЙДВЭРЛЭСЭН нь: "Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хянан зохицуулах үүрэг бүхий үндэсний зөвлөлийн ажиллах журам"-ын 1 дүгээр хэсгээс ".. тэгш.." гэсэн үгийг хасахаар тогтов.

Танилцуулах асуудал

ҮII. Монгол Улсад олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлага /ОУИТБС/-д зориулсан дэмжлэг-Буцалтгүй тусламж хүсэх санал /Д.Батбаяр танилцуулав/ Үүнтэй холбогдуулан олон талт доноруудын Итгэлийн сангаас буцалтгүй тусламж авах ажлыг холбогдогч талуудтай харилцан зохион байгуулахыг Үндэсний зөвлөлийн гишүүн, Сангийн сайд Н.Баяртсайхан, Үндэсний зөвлөлийн нарийн бичгийн дарга Д.Батбаяр нарт даалгав.

Үндэсний зөвлөлийн хуралдааны хааж Үндэсний зөвлөлийн дарга М.Энхболд дараахь үг хэлэв.

Үндэсний зөвлөлийн хуралдаан хэлэлцэх асуудлаа амжилттай хэлэлцлээ. Хэлэлцсэн асуудал бүрт Үндэсний зөвлөлийн гишүүдийн гаргасан саналыг судлан тусгаж батлуулах арга хэмжээг Д.Батбаяр хариуцна. Ажлын хэсэг тусална. Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагыг хэрэгжүүлэх чиглэлээр оролцогч 3 талын санамж бичигт гарын үсэг зурах үйл ажиллагааг ойрын үед зохион байгуулая.

Үндэсний зөвлөлийн гишүүд энэхүү санаачлагыг хэрэгжүүлэх чиглэлээр шинэчилсэн төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, үйл ажиллагааг өөр өөрийн хариуцсан салбар, хийх ажлаа бүрэн хариуцах, түүний хэрэгжилтэд байнгын хяналт тавьж ажиллацгаая. Энэхүү санаачлагыг хэрэгжүүлэхэд зориулж Олон талт хандивлагчдын Итгэлийн сангаас буцалтгүй тусламж авах ажил жаахан удааширч байгаа ч үүнийг хурдавчлан авч эхлүүлэх ажлыг Сангийн сайд Н.Баяртсайхан, Үндэсний зөвлөлийн нарийн бичгийн дарга Д.Батбаяр нар Дэлхийн банкны суурин төлөөлөгчийн газартай байнга харилцаж авах хэрэгтэй байна. Санаачлагыг хэрэгжүүлэхэд урьдчилсан бэлтгэл ажил болсон сургалт, семинар зохион байгуулах ажлыг эртнээс хангахад Үндэсний зөвлөл, ажлын хэсгийн гишүүдийн анхаарлыг төвлөрүүлж ажиллахыг Ажлын хэсгийн ахлагч Д.Батбаярт даалгаж байна.

Санаачлагад аж ахуйн нэгжийг сонгох, сонгосон аж ахуйн нэгжийн улс, орон нутагт 2006 онд төлсөн албан татвар, төлбөрийн тайланг гаргахад туслах, биелэлтэд хяналт тавих ажил гарна.

Мөн сонгосон аж ахуйн нэгжээс улс, орон нутагт 2006 онд хүлээн авсан албан татвар, төлбөрийн тайланг Сангийн яам хариуцан төр, орон нутгийн

тул нэгж, ажилтнуудтай байгуулсан гэрээнд өөрчлөлт орох зэрэг ажил гарах байх.

Санаачлагыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Үндэсний зөвлөл, ажлын хэсгийн гишүүдийг төв, орон нутагт ажиллуулна. Энэ талаар холбогдох арга зүйгээр ажлын хэсэг хангана. Үндэсний зөвлөлийн гишүүд бид өөрсдөө асуудлынхаа мөн чанарыг, агуулгыг сайн судлах хэрэгтэй байна. Үүний тулд цөөн цагийн хичээл хүртэл заалгах, ярилцлага зохиох хэрэгцээ гарч байна.

Санаачлагын ач холбогдол, мөн чанарын талаар, энэ чиглэлээр Ажлын хэсэг, Үндэсний зөвлөлөөс хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, цаашид зохиох ажлын талаар сурталчилгаа сайн хийх, ялангуяа төрийн бус байгууллагатай хамтран ажиллах хэрэгтэй байна. Санаачлагын хэрэгжилтэд тавих хяналтыг төрийн бус байгууллага, олон нийтийн зүгээс тавьж байгаа, цаашид улам цэгцтэй, тодорхой хяналт тавигдана.

Хийгдэж байгаа ажил, үйл ажиллагааны талаар зөвлөлийн гишүүдийг хангах зорилгоор мэдээлэл өгөх, заавал хурал гэлгүйгээр гишүүдэд мэдээлэл өгч байх чухал байна. Санаачлагын анхны жилийн 2 талын тайланг гаргах ажлыг сайтар зохион байгуулах, хянан зохицуулах нь Үндэсний зөвлөлийн үүрэг болж байна. Иймд манай Үндэсний зөвлөлийн гишүүд энэхүү асуудалд анхнаас нь хариуцлагатай хандаж, нэр төртэй биелүүлнэ гэдэгт итгэж байна.

Үндэсний зөвлөлийн хуралдааны 13 цагт дуусав.


Товч тэмдэглэл хөтөлсөн:

Засгийн газрын ахлах референт

 Э.СУМЪЯА

Танилцсан:

Үндэсний зөвлөлийн нарийн бичгийн дарга

 Д.Батбаяр